



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 616

Улаанбаатар хот

### Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 268 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 4 дахь хэсэгт дор дурдсан нэмэлт өөрчлөлт оруулсугай.

1.1. “4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт үүрэг болгосугай” гэж өөрчлөн найруулах;

1.2. “4.7. Ажлын хэсэгт томилогдсон албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг чанд сахин, авлигаас ангид, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллаж, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ” гэж;

1.3. “4.8. Дуудлага худалдаа зохион байгуулах явцад гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй гарсан, гарах нөхцөл бүрдсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлийг олж мэдсэн тохиолдолд нэн даруй эрх бүхий байгууллага, этгээдэд мэдэгдэнэ” гэж;

1.4. “4.9 Дуудлага худалдаа зохион байгуулахтай холбоотой асуудлаар авлига, ашиг сонирхлын зөрчил үүссэн нь нотлогдсон тохиолдолд дуудлага худалдааг цуцалж, учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ” гэж;

1.5. “4.10 Төрийн өмчит хуулийн этгээдийн зохион байгуулсан дуудлагын худалдааны үр дүнгээр худалдах, худалдан авах гэрээнд оролцогч талуудыг төлөөлж буй этгээд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх тохиолдолд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан мэдэгдлийг гаргаж, өөрийн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд бүртгүүлнэ” гэж.

123006586

32-r\_huraldaan.docx

2. Тогтоолыг нийт төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

